



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/115/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 261885 Цахим хаяг: <a href="mailto:tsogbayar.a@audit.mn">tsogbayar.a@audit.mn</a></p> <p>Аудитор: С.Болортуяа Утас: 261740 Цахим хаяг: <a href="mailto:bolortuya.s@audit.mn">bolortuya.s@audit.mn</a></p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: <a href="mailto:info@suld-audit.mn">info@suld-audit.mn</a></p>
---------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ  
ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ТӨСЛИЙН  
ЗОХИЦУУЛАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.АСЫЛ  
ТАНАА

2025.03.17 № 07/1072  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Төслийн хүрээнд хийгдсэн Хөвсгөл, Ховд, Дундговь, Дорнод, Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, хөгжлийн 36,386,465.1 мянган төгрөгийн нэгдсэн төвийн барилга угсралтын ажил бүрэн дуусаж, тус аймаг, хотын Хөдөлмөр, халамж үйлчилгээний төвүүдэд шаардлагатай 8,459,011.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өгсөн.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээс ашиглагдаагүй 8,185.0 мянган ам.долларын үлдэгдэл эх үүсвэрийг ашиглах замаар Завхан аймаг болон Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэгт "Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв"-г шинээр барих ажлыг гүйцэтгэхээр шийдвэрлэж, төсөл хэрэгжүүлэх хугацааг сунгах хүсэлтийг Азийн хөгжлийн банканд хүргүүлж, төсөл хэрэгжих хугацааг 2 жилээр буюу 2026 оны 10 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгах зөвшөөрөл олгосон байна.

### Бусад асуудлын хэсэг

Төслийн үндсэн 5 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 2024 онд нийт 52 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс бүрэн хэрэгжсэн 32, тодорхой үр дүнд хүрсэн 4, эрчимжүүлэх шаардлагатай 12, зорилтот түвшиндээ хүрээгүй 4 арга хэмжээ бөгөөд нийт хэрэгжилт 78.0 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгаар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>47,150,759,413.42</b>	<b>4,901,775,782.25</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	1,287,665,282.50	1,607,446,973.23
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,287,665,282.50</b>	<b>1,607,446,973.23</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>637,256,459.47</b>	<b>290,290,912.93</b>
31213	Төрийн сангийн харилцах	637,256,459.47	290,290,912.93
3122	<b>Гадаад валют</b>	<b>650,408,823.03</b>	<b>1,317,156,060.30</b>
31221	Төрийн сангийн харилцах	650,408,823.03	1,317,156,060.30
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>543,244,548.26</b>	<b>3,066,079.66</b>
34600	Урьдчилж гарсан зардал	543,244,548.26	3,066,079.66
<b>36</b>	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>45,319,849,582.66</b>	<b>3,291,262,729.36</b>
36800	Бусад эргэлтийн хөрөнгө	45,319,849,582.66	3,291,262,729.36
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>98,957,388.89</b>	<b>77,753,153.00</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>98,957,388.89</b>	<b>77,753,153.00</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>98,957,388.89</b>	<b>77,753,153.00</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	152,730,000.00	152,730,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(71,274,000.00)	(86,547,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,125,366.00	54,125,366.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(51,049,687.11)	(54,095,781.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	28,851,420.00	28,851,420.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,425,710.00)	(17,310,852.00)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	-	-
39301	Програм хангамж	7,150,000.00	7,150,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(7,150,000.00)	(7,150,000.00)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>47,249,716,802.31</b>	<b>4,979,528,935.25</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,240,932,919.02</b>	<b>1,284,995,359.90</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>3,240,932,919.02</b>	<b>1,284,995,359.90</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>3,240,932,919.02</b>	<b>1,284,995,359.90</b>
413100	Ажилчидтай холбогдсон өглөг	128,666.68	426,560.71
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	3,232,991,812.26	1,260,712,770.07
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>7,812,440.08</b>	<b>23,856,029.12</b>
41361	Татварын өглөг /ТӨҮГ/	7,812,440.08	23,856,029.12
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>44,008,783,883.29</b>	<b>3,694,533,575.35</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>44,008,783,883.29</b>	<b>3,694,533,575.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	29,263,098,655.56	44,008,783,883.29
51220	Тайлант үеийн үр дүн	14,745,685,227.73	(40,314,250,307.94)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>47,249,716,802.31</b>	<b>4,979,528,935.25</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>15,732,402,267.66</b>	<b>6,210,934,710.77</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15,732,402,267.66</b>	<b>6,210,934,710.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>14,518,402,801.76</b>	<b>5,730,073,073.07</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>14,517,652,801.76</b>	<b>5,498,981,253.07</b>
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	14,517,388,123.76	5,498,981,253.07
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	264,678.00	0.00
120009	Бусад орлого	750,000.00	231,091,820.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>1,213,999,465.90</b>	<b>480,861,637.70</b>
122002	Хандив тусламж /гадаад/	1,213,999,465.90	480,861,637.70
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>970,610,633.94</b>	<b>1,679,163,660.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>970,610,633.94</b>	<b>1,679,163,660.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>970,610,633.94</b>	<b>1,679,163,660.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>416,098,993.49</b>	<b>347,558,151.65</b>
210101	Үндсэн цалин	416,098,993.49	347,558,151.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,012,374.19</b>	<b>35,986,721.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	52,012,374.19	35,986,721.13
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,843,674.29</b>	<b>9,666,146.99</b>
210401	Бичиг хэрэг	4,584,858.33	3,163,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,684,340.00	1,485,217.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,574,475.96	4,832,429.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	185,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>12,114,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	5,114,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>40,320,149.00</b>	<b>10,039,488.01</b>
210702	Дотоод албан томилолт	40,320,149.00	10,039,488.01
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>424,312,300.50</b>	<b>1,240,171,885.01</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	377,224,180.00	1,213,888,038.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,000,000.00	25,999,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,048.00	284,247.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	11,867,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	87,072.50	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,023,142.47</b>	<b>23,626,467.71</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	463,516.00	2,422,231.82
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,559,626.47	21,204,235.89
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>14,761,791,633.72</b>	<b>4,531,771,050.27</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>101,651.00</b>
145002	Шатахууны картын хөнгөлөлт	0.00	101,651.00
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>16,106,405.99</b>	<b>44,846,123,009.21</b>
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	16,106,405.99	646,303.16
225012	Хөрөнгө оруулалтын зориулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зорилготой хөрөнгийн зардал	0.00	44,845,476,706.05
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(16,106,405.99)</b>	<b>(44,846,021,358.21)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>14,745,685,227.73</b>	<b>(40,314,250,307.94)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,692,598,349.31</b>	<b>6,210,944,710.77</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,692,598,349.31</b>	<b>6,210,944,710.77</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>1,692,598,349.31</b>	<b>5,730,083,073.07</b>
1200044	<b>Гадаадын эх үүсвэрээс санхүүжих</b>	<b>1,691,848,349.31</b>	<b>5,498,981,253.07</b>
120009	Бусад орлого	1,691,848,349.31	5,498,981,253.07
120010	Гүйцэтгэлийн баталгааны орлого	750,000.00	10,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	0.00	231,091,820.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>841,743,040.36</b>	<b>1,550,793,599.16</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>841,743,040.36</b>	<b>1,550,793,599.16</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>841,743,040.36</b>	<b>1,550,384,915.16</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>401,973,260.92</b>	<b>331,226,668.58</b>
210101	Үндсэн цалин	401,973,260.92	331,226,668.58
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>58,197,000.00</b>	<b>35,986,721.13</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,197,000.00	35,986,721.13
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>11,406,375.96</b>	<b>10,646,929.00</b>
210401	Бичиг хэрэг	4,831,900.00	3,163,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,000,000.00	2,466,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,574,475.96	4,832,429.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		185,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,684,340.00</b>	<b>12,114,800.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,684,340.00	7,000,000.00
210604	Урсгал засвар		5,114,800.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>36,544,889.00</b>	<b>10,260,625.00</b>
210702	Дотоод албан томилолт	36,544,889.00	10,260,625.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>330,937,174.48</b>	<b>1,150,149,171.45</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	8,256,733.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	35,000,000.00	25,999,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	134,048.00	284,247.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,907,000.00	0.00
210813	Зөвлөх үйлчилгээний зардал	279,896,126.48	1,114,882,084.31
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	0.00	726,506.15
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>408,684.00</b>
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>408,684.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	408,684.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>850,855,308.95</b>	<b>4,660,151,111.61</b>
5	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>267,002,730.28</b>	<b>4,339,723,117.72</b>
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>267,002,730.28</b>	<b>4,339,723,117.72</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>267,002,730.28</b>	<b>4,339,723,117.72</b>
220001	Барилга байгууламж	267,002,730.28	3,692,464,679.72
221001	Их засвар		647,258,438.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(267,002,730.28)</b>	<b>(4,339,723,117.72)</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(16,569,923.00)</b>	<b>(646,303.16)</b>
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	16,106,407.00	646,303.16
250006	Бусад зардал	463,516.00	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>567,282,655.67</b>	<b>319,781,690.73</b>
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>720,382,626.83</b>	<b>1,287,665,282.50</b>
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,287,665,282.50</b>	<b>1,607,446,973.23</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>29,263,098,655.56</b>	<b>29,263,098,655.56</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-		
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>29,263,098,655.56</b>	<b>29,263,098,655.56</b>
Тайлант үеийн үр дүн		14,745,685,227.73	14,745,685,227.73
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>44,008,783,883.29</b>	<b>44,008,783,883.29</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	<b>44,008,783,883.29</b>	<b>44,008,783,883.29</b>
Тайлант үеийн үр дүн	-	(40,314,250,307.94)	(40,314,250,307.94)
<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	<b>3,694,533,575.35</b>	<b>3,694,533,575.35</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,931,500,000.00</b>	<b>5,889,381,526.73</b>	<b>1,042,118,473.27</b>	<b>85.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,626,000,000.00</b>	<b>1,549,658,409.01</b>	<b>76,341,590.99</b>	<b>95.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,626,000,000.00</b>	<b>1,549,658,409.01</b>	<b>76,341,590.99</b>	<b>95.3</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>340,099,000.00</b>	<b>331,226,668.58</b>	<b>8,872,331.42</b>	<b>97.4</b>
210101	Үндсэн цалин	340,099,000.00	331,226,668.58	8,872,331.42	97.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>50,000,000.00</b>	<b>35,986,721.13</b>	<b>14,013,278.87</b>	<b>72.0</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,000,000.00	26,017,467.67	7,982,532.33	76.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,000,000.00	3,475,581.52	524,418.48	86.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,000,000.00	0.00	2,000,000.00	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,000,000.00	559,515.43	1,440,484.57	28.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,000,000.00	5,934,156.51	2,065,843.49	74.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,215,000.00</b>	<b>10,646,929.00</b>	<b>1,568,071.00</b>	<b>87.2</b>
210401	Бичиг хэрэг	4,221,000.00	3,163,500.00	1,057,500.00	74.9
210402	Тээвэр, шатахуун	2,700,000.00	2,466,000.00	234,000.00	91.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,109,000.00	4,832,429.00	276,571.00	94.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	185,000.00	185,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,895,000.00</b>	<b>12,114,800.00</b>	<b>1,780,200.00</b>	<b>87.2</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,780,000.00	7,000,000.00	1,780,000.00	79.7
210604	Урсгал засвар	5,115,000.00	5,114,800.00	200.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>10,260,625.00</b>	<b>4,739,375.00</b>	<b>68.4</b>
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	10,260,625.00	4,739,375.00	68.4
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,194,791,000.00</b>	<b>1,149,422,665.30</b>	<b>45,368,334.70</b>	<b>96.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,167,831,000.00	1,123,138,818.30	44,692,181.70	96.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	26,000,000.00	25,999,600.00	400.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	960,000.00	284,247.00	675,753.00	29.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,305,500,000.00</b>	<b>4,339,723,117.72</b>	<b>965,776,882.28</b>	<b>81.8</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>5,305,500,000.00</b>	<b>4,339,723,117.72</b>	<b>965,776,882.28</b>	<b>81.8</b>
220001	Барилга байгууламж	4,323,500,000.00	3,692,464,679.72	631,035,320.28	85.4
222001	Тоног төхөөрөмж	982,000,000.00	647,258,438.00	334,741,562.00	65.9
<b>3</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,931,500,000.00</b>	<b>6,210,944,710.77</b>	<b>720,555,289.23</b>	<b>89.6</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,084.0 мянган төгрөгийн 1 зөрчил<sup>1</sup>-г давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Албан томилолтын шатахууны зардалд 1,084.0 мянган төгрөгийг зарцуулж, уг зардалд хамааралгүй баримтыг /э-баримтын сугалааны дугаартай/ хавсаргасан.	1	1,084.0					1	1,084.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>1,084.0</b>					<b>1</b>	<b>1,084.0</b>				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2 зөрчил илэрснээс, 1 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж, 1 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>										
Шилэн дансны тухай хуулийн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна	1	377,874.7					1	377,874.7		
<b>Бусад хууль тогтоомжийн хүрээнд</b>										
Архангай аймгийн ХБХХТ-ийн барилгын ажлын гүйцэтгэл хангалтгүй.	1	-							1	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>377,874.7</b>					<b>1</b>	<b>377,874.7</b>	<b>1</b>	<b>-</b>